



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 67,396,000.00 (жаран долоон сая гурван зуун өрэн зургаан мянган) төгрөгийн балансын үнэ, хурумтлагдсан элэгдэл бүхий Ландкруйзер-200 маркийн автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагч А.Энхзул наарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТОРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
3/8 дугаар тогтоолын хавсралт

“ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашины марк улсын дугаар	Ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинээр бүртгэх үнэ	Цаашид ашиглах хугацаа /жил/	Шилжүүлэн авах байгууллага
1	Ландкруйзер-200 09-85 үнү	3/19/2010	JTMHU09J204 013554	67,396,000.00	67,396,000.00	12,000,000.00	3	Замын-Үүд чөлөөт бусийн захирагч
	НИЙТ ДҮН			67,396,000.00	67,396,000.00			
				/жаран долоон сая турван зуун ерэн зургаан мянган/	/Арван хоёр сая/			